| 65     | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                                    | <b>24.00</b> | <b>24.00</b>  |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 24.00        | 24.00         |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зэрэг сумын Эрүүл мэндийн төв нь хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжийг сайжруулах, хүн амыг эрүүлжүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн иргэдийнхээ эрүүл мэндийг дээдэлж, аймгийн түвшинд тэргүүлсэн, ёс зүйтэй чадварлаг хамт олонтой, үйлчлүүлэгчдэд ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ гэсэн алсын харааг тодорхойлж, Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах жил болгон зарласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн байна. Дараах тогтоолуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байна. Үүнд:

- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай ”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай ”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай”

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зэрэг сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд ДУНД гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтгүй гэж үзлээ

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зэрэг сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 187.1 сая төгрөгөөр буцуу 19.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| /сая.төгрөгөөр/                                  |                |                 |              |
|--|----------------|-----------------|--------------|
| Үзүүлэлт   | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт     |
| <b>Б</b>   | <b>1</b>       | <b>2</b>        | <b>3=2-1</b> |
| Мөнгөн хөрөнгө                                   |                | 75.2            | 75.2         |
| Авлага   | 66.4           | 0               | -66.4        |
| Бараа материал                                   | 50.2           | 60.4            | 10.2         |
| Үндсэн хөрөнгө                                   | 847.2          | 1015.3          | 168.1        |
| <b>Нийт хөрөнгө</b>                              | <b>963.8</b>   | <b>1151.0</b>   | <b>187.1</b> |
| Өр төлбөр  | 2.1            | 0.8             | -1.3         |
| Засгийн газрын хувь оролцоо<br>/Эздийн өмч/      | 961.7          | 1150.2          | 188.5        |
| <b>Өр төлбөр ба цэвэр<br/>хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>963.9</b>   | <b>1151.0</b>   | <b>187.1</b> |

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Байгууллага нь гүйцэтгэлээр санхүүждэг болсны дагуу Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаар тоот албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 75.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Өмнөх онд аймгийн эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөртэй үйлчилгээний авлага 65.8 сая төгрөг, эмийн боох материалын авлага 0.5 сая байсныг тайлант онд санхүүжилтээр авч авлага барагдуулан ажилласан.
- ✓ Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 10.2 сая төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлээр санхүүжилт авч байгаатай холбоотой тайлант хугацаанд Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл, сумын ОНХС-аас 2.5 сая төгрөгөөр багийн эмчид эмийн фонд, нэг оношлуур, төстийг үнэ төлбөргүйгээс олгогдож зарцуулаагүйгээс үлдэгдэлтэй байна.
- ✓ Өр төлбөрийн хувьд өмнөх онд үүссэн өглөгийг тайлант онд 1.3 барагдуулан, тайлант онд 0.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны орон нутгийн төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 37.2 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 882.5

сая төгрөг бүгд 919.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж тайлант оны эхэнд 882.5 сая төгрөгөөр баталжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 762.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 37.1 сая төгрөг, ЭМГ-аас 0.4 сая төгрөг нийт 799.9 сая төгрөгийн санхүүжилт авч 724.7 сая төгрөгийг зарцуулан 75.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

| /сая. төгрөгөөр/                          |   |            |           |        |         |
|---|---|------------|-----------|--------|---------|
| Д/д                                       | Хөтөлбөр, арга хэмжээ                               | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү  | Биелэлт |
| <b>71602- Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b> |   |            |           |        |         |
| 1   | 71602/80302- Нэг иргэнд ногдох нормативаар          | 457.6      | 402.4     | -55.2  | 87.9    |
| 2   | 71602/81603- Үндсэн мэргэжлийн тусламж              | 305.4      | 241.1     | -64.3  | 78.9    |
| 3   | 71602/83603- Нэмэлт- дээд шатны төсвөөс хуваарилсан | 119.3      | 119.3     | 0      | 100.0   |
| 4   | 71602/80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал  | 34.8       | 33.8      | -1     | 97.1    |
| 5   | 71602/80112- Нийтлэг үйлчилгээ                      | 2.4        | 2.2       | -0.2   | 91.7    |
| ДҮН                                       |   | 919.5      | 798.8     | -120.7 | 86.9    |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өмнөх оны 66.4 сая төгрөгийн авлагыг ЭМДС-аас нэмэлт санхүүжилтийн дансаар авч 66.4 сая төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлэн эмчилгээ үйлчилгээ, ажилчдын цалин хөлс, тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулжээ.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зэрэг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор У.Батчимэг 2023 оны 02 дугаар сарын 25-ноос 02 дугаар сарын 28-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 албан бичгээр ирүүлсэн байна.

#### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 527.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.2 сая төгрөгөөр тогтоосон байсныг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.5 хувиар буюу 11.4 сая төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 9.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Ховд аймгийн Зэрэг сумын ЭМТөв нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 9 дүгээр зүйлд албан томилолт, 10 дугаар зүйлд холбоотой заалтууд хамаарахгүй байна.

14 дүгээр зүйлд заасан зөрчлийн дэлгэрэнгүйг тайлангийн 5-д харуулав.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн 6.4.5-д заасны дагуу тайлант онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 36 ажил мэдээлээгүй, 14 ажил гүйлгээг мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

#### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 0.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 17.1 сая төгрөгийн 2 албан шаардлага, 3 зөвлөмж өгөгдөж хэрэгжилт 100 хувьтай хэрэгжүүлэн ажиллажээ.

*Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |           | Биелэлт  |           |            |
|-----------------|------------------------|-----------|----------|-----------|------------|
|                 | Тоо                    | Дүн       | Тоо      | Дүн       | Хувь       |
| Акт             | 1                      | 0.8       | 1        | 0.8       | 100        |
| Албан шаардлага | 2                      | 17.1      | 1        | 17.1      | 100        |
| Зөвлөмж         | 3                      | 15.0      | 3        | 15.0      | 100        |
| <b>Нийт дүн</b> | <b>6</b>               | <b>33</b> | <b>5</b> | <b>33</b> | <b>100</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, салбарын зохион байгуулдаг худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийн хэрэгцээ шаардлага, эм, шатахууныг нарийн анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 138.1 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрсэн тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтын дагуу санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Худалдан авсан эм боох материалын 1.1 сая төгрөгийг үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрсөн,
- ЭМГ-аас ирүүлсэн эм эмнэлгийг хэрэгслийг 0.4 сая төгрөгөөр дутуу,
- Бараа материалын шинж чанартай 7.6 сая төгрөгийн хөрөнгийн үндсэн хөрөнгөд,
- Хандиваар хийгдсэн эмнэлгийн гадна засвар 87.0 сая төгрөгийг капиталжуулсан,
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний эхо аппарат, санхүүгийн СИ ТИ ЭС программ 41.8 сая төгрөгийн хөрөнгийг дутуу орлого авсныг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 40.3 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 11.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 25.4 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүллээ.

#### 5.1 Төлбөрийн акт

- Нийт ажилчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор 9.2 сая төгрөгийн урамшуулалт цалин давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Хандив тусламжийн орлогыг хувь хүний нэр дээр харилцах данс нээн зарцуулж үлдэгдлийг төвлөрүүлээгүй 2.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т "Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хүсэхийг хориглоно” 17.3-т “Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т “Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-т “Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана” гэсэн заалттай нийцээгүй байна.

## 5.2 Зөвлөмж

### 5.2.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой

**Илрүүлэлт:** Модерн мебел ХХК, Ашид буян ХХК, Мед буян трейд ХХК-аас 24.2 сая төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрт худалдан авах хүсэлт байршуулахгүйгээр шууд худалдан авах гэрээ байгуулж төлбөрийг шилжүүлсэн зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” 14.2.Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа ТӨБЗГ-т саналаа хүргүүлж, цахим дэлгүүрээс худалдан авалт хийж, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

### 5.2.2 Нэмэгдэл цалин хөлстэй холбоотой

**Илрүүлэлт:** Үйлчилгээний ажилтан нь 1.2 сая төгрөгийн илүү цагаар ажиллаж нэмэгдэл хөлс авсан нь илүү цагаар ажиллахдаа хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг тодорхой үнэлээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Илүү цагийн нэмэгдлийг олгоходоо нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг үнэн зөв хөтөлж хэвших, цаг бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах.

### 5.2.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .

**Илрүүлэлт** Шилэн дансны хуулийн 6.4.5-д заасны дагуу тайлант онд орлогын 36 ажил гүйлгээнээс 36 гүйлгээг мэдээлээгүй, 14 ажил гүйлгээг мэдээллийг хугацаа хоцроож, мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдэгдлийг тогтмол мэдээлнэ” хуулийн заалтыг зөрчсөн байна

**Өгсөн зөвлөмж** Шилэн дансны тухай хуулийг мөрдөн ажиллаж 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ, хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийн мэдээллийг бүрэн байршуулж хэвших

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөг/

| Алдааны товч утга | Нийт алдаа | Үүнээс | Зөвлөмж |
|-------------------|------------|--------|---------|
|-------------------|------------|--------|---------|

|   |          |              | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |              | Буруу тусган илэрхийлсэн |          | Залруулсан |              | Залруулаагүй |     |     |     |
|---|----------|--------------|-----------------------------------|--------------|--------------------------|----------|------------|--------------|--------------|-----|-----|-----|
|   | Тоо      | Дүн          | Тоо                               | Дүн          | Тоо                      | Дүн      | Тоо        | Дүн          | Тоо          | Дүн | Тоо | Дүн |
| Худалдан авсан эм боох материалын үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрсөн,                             | 1        | 1.1          | 1                                 | 1.1          |                          |          | 1          | 1.1          |              |     |     |     |
| БМҮнэгүй орлого 0.4 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн   | 1        | 0.5          | 1                                 | 0.5          |                          |          | 1          | 0.5          |              |     |     |     |
| Бараа материалын шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэн хөрөнгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн | 1        | 7.7          | 1                                 | 7.7          |                          |          | 1          | 7.7          |              |     |     |     |
| Хандиваар хийгдсэн эмнэлгийн гадна засвар 87.0 сая төгрөгийг барилга байгууламжид орлого авсан          | 1        | 87.0         | 1                                 | 87.0         |                          |          | 1          | 87.0         |              |     |     |     |
| Эхо аппарат, санхүүгийн CTS программ ханагмж үндсэн хөрөнгөд орлого авалгүй орхигдуулсан                | 1        | 41.8         | 1                                 | 41.8         |                          |          | 1          | 41.8         |              |     |     |     |
| <b>Дүн</b>  | <b>5</b> | <b>138.1</b> | <b>4</b>                          | <b>138.1</b> | <b>0</b>                 | <b>0</b> | <b>5</b>   | <b>138.1</b> |              |     |     |     |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөг/

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |             | Үүнээс        |             |                 |          |          |             |                                      |                     |   |     |
|---|-------------|-------------|---------------|-------------|-----------------|----------|----------|-------------|--------------------------------------|---------------------|---|-----|
|   |             |             | Төлбөрийн акт |             | Албан шаардлага |          | Зөвлөмж  |             | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|   | Тоо         | Дүн         | Тоо           | Дүн         | Тоо             | Дүн      | Тоо      | Дүн         | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |
| Хөрөнгө худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй          | 1           | 24.1        |               |             |                 |          | 1        | 24.1        | -                                    | -                   | -   | -   |
| Урамшуулалт цалин давхардуулсан олгосон                                     | 1           | 9.2         | 1             | 9.2         |                 |          |          |             |                                      |                     |   |     |
| Хандив тусламжийн орлогыг хувь хүний нэр дээр харилцах данс нээн зарцуулсан | 1           | 2.2         | 1             | 2.2         |                 |          |          |             |                                      |                     |   |     |
| Илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон   | 1           | 1.2         |               |             |                 |          | 1        | 1.2         | -                                    | -                   | -   | -   |
| <b>Нийт дүн</b>   | <b>4</b>    | <b>36.7</b> | <b>2</b>      | <b>11.4</b> | <b>0</b>        | <b>0</b> | <b>2</b> | <b>25.3</b> |                                      |                     |   |     |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                       | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|  |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|  | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |     |               |     |                 |     |         |     |

|  |   |   |   |   |   |   |   |  |
|--|---|---|---|---|---|---|---|--|
| Цалингийн зардлаас<br>бусад 5 сая төгрөгөөс<br>дээш үнийн дүн бүхий<br>орлого, мэдээлээгүй | 1 | - |   |   |   |   | 1 |  |
| Дүн  | 1 | - | - | - | - | - | 1 |  |


**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *[Signature]* Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: *[Signature]* А.ЦЭЦЭГСҮРЭН

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

АУДИТОР: *[Signature]*



У.БАТЧИМЭГ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 1/A2171039

Ховд

ХОА-2022/137/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд аймгийн Зэрэг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар байгууллагын эмч, ажилчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор олгосон урамшуулалт цалин хөлсийг 8,11 дүгээр саруудад давхардуулан 9,203.1 мянган төгрөг, албан томилолтын зардалд 28.0 мянган төгрөг илүү олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээр дурдсан 9,231,100 /есөн сая хоёр зуун гучин нэгэн мянга нэг зуун/ төгрөгийг хавсралтад дурдсан ажилчдаас суутган тооцож Төрийн сан банкин дахь бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 5 дүгээр сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Зэрэг сумын Эрүүл мэндийн төвийн дарга М.Отгончимэг, нягтлан бодогч Ц.Энхтуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Х.Болсук* БОЛДВААТАР

АУДИТОР *У.Батчимэг* У.БАТЧИМЭГ

<sup>1</sup> Монгол улс, Ховд аймаг, Цамбагарае баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас: 70433061, 70432545



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 25/A2171039

Ховд

ХОА-2022/137/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд аймгийн Зэрэг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар хандив тусламжийн орлогын дансыг хувь хүний нэр дээр харилцах данс нээн зарцуулж үлдэгдлийг төвлөрүүлээгүй 2,262.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т "Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно" 17.3-т "Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т "Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээр дурдсан 2262600 /хоёр сая хоёр зуун жаран хоёр мянга зургаан зуун/ төгрөгийг Зэрэг сумын Эрүүл мэндийн төвийн Төрийн сан банкин дахь 100160620010 тоот дансанд 2023 оны 04 дүгээр сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>2</sup> ирүүлэхийг Зэрэг сумын Эрүүл мэндийн төвийн дарга М.Отгончимэг, нягтлан бодогч Ц.Энхтуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Х.БОЛДБААТАР*  
АУДИТОР *У.БАТЧИМЭГ*

<sup>2</sup> Монгол улс, Ховд аймаг, Цамбагараа баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас: 70433061, 70432545